

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



ХҮНИЙГ ХҮНДЭЛ ((ХҮНИЙГ ХҮНДЭЛ)) ХҮНИЙГ ХҮНДЭЛ ХҮНИЙГ ХҮНДЭЛ ХҮНИЙГ ХҮНДЭЛ

© Б. Чингүүн

((ХҮНИЙГ ХҮНДЭЛ))



© Б. Чингүүн

Дэлхийн дахины ядуурлын талаар ойлголт авахын тулд заавал Эмнести Интернэшнлд хандах шаардлагагүй. Та өөрөө хангалттай ойлголттой ч байж магадгүй юм. Ядуурлыг бууруулах санаа гаргахад тань ч Эмнести Интернэшнлийн оролцоо чухал бус. Тийм санаа маш олон байгаа бөгөөд алийг нь дэмжих эсэх нь маргаантай.

Гэхдээ хэрэв 963 сая хүн үдэш бүр өлсгөлөн унтдаг, 1 тэрбум хүн ядуусын хороололд амьдардаг, жирэмслэлтээс үүдэн хором тутамд 1 эмэгтэй амиа алддаг, 1.3 тэрбум хүн эрүүл мэндийн наад захын үйлчилгээ авах боломжгүй, 2.5 тэрбум хүн зохих ариун цэвэр, усны үйлчилгээнд хамрагдаагүйгээс 20000 хүүхэд нас бардаг байдлыг өөрчлөхийг хүсвэл та биднийг сонсох хэрэгтэй.

Ямар ч төлөвлөгөөг баримталсан, ямар ч төслийг чухалчилж, ямар ч тусламжийн багц дээр төвлөрсөн ч хүний эрхэнд тулгуурлаагүй л байвал урт хугацаанд ямар ч нааштай үр нөлөө үзүүлэхгүй. Ядууралд нэрвэгдсэн хүмүүсийн эрхийг хамгаалах нь энгийн л нэг хувилбар биш, харин тухайн арга замын салшгүй нэг хэсэг нь байх ёстой юм.

Ядуусзөвхөн эд юмаар гачигддаггүй. Харин тэд гадуурхагдаж, үг нь үл сонсогдож, дарамтанд өртөх аюултай хавханд орсон байдаг. Эрхээ эдлэх нь л тэр хавхнаас салгах түлхүүр мөн.

Төр иргэдийнхээ айдас, гачигдлаас ангид эрх чөлөөтэй амьдрахыг нь баталгаажуулах, оролцох, үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох тухай хүний эрхийн баримт бичгүүдэд туссан байдаг. Хүнийг бүрэн утгаар нь хүндэлж чадвал хүн бүр нэр төртэй амьдрах, хоол, ус, эрүүл мэнд, боловсрол, орон байрны наад захын үйлчилгээнд хамрагдах эрхээ эдлэнэ. Олон улсын хууль, түгээмэл жишгээр хуульчлагдсан эдгээр заалт нь ядуу зүдүү амьдралтай хүмүүст өөрсдийг нь «барьцаалсан» эрх мэдлийн тэгш бус байдлыг тэнцвэржүүлэх хэрэгсэл болно.

Улс орнууд хөгжлийн үзэл санааныхаа төвд хүний эрхийг дээдэлсэн байх ёстой. Та үүнийг урд нь сонссон шиг санагдаж магад. Олон хүн үүнийг мэддэг ч, маш цөөхөн нь үйл ажиллагаандаа хүний эрхийг анхаардаг. Дийлэнх засгийн газар, олон улсын хэмжээний оролцогчдын хувьд хүний эрх бол зүгээр л «цаасан дээрх» хоёр үг. Тиймээс хөгжлийн гэж нэрлэгддэг төслүүд нь ядуучуудын байдлыг улам хүндрүүлж байдаг юм. Эдийн засгийн өсөлт нь чухал үзүүлэлт мөн ч дангаараа ядууралд харилт өгч чадахгүй. Учир нь гадуурхагдмал хэсгийн амьдрал сайжраагүй, тэгш бус байдал улам даамжирч байсан ч эдийн засгийн өсөлт нь амжилтанд тооцогддог.

Дэлхийн ядуурлын эсрэг төлөвлөгөө болох Мянганы Хөгжлийн Зорилт /МХЗ/ хүмүүсийг ядууруулж, ядуу хэвээр нь уяад байгаа тэрхүү зөрчлүүдээс цөөхнийг нь л анхааралдаа авсан. Жишээ нь

үндэсний болон шашны цөөнх, уугуул нутгийнхан, охид эмэгтэйчүүд дэлхийн ядуучуудын ихэнхийг нь бүрдүүлдэг байхад МХЗ -оос ядуурал нь нийгмийн эдгээр бүлэг бүрт яаж нөлөөлдөг тухай тайлбар Засгийн газруудаас шаарддаггүй. Цаашлаад засгийн газруудад хүмүүсийг ядууруулдаг, ядуу хэвээр нь байлгадаг, МХЗ-ын хэрэгжилтэнд саад болдог хүний эрхийн зөрчлүүдийг арилгахыг шаарддаггүй бөгөөд амлалтандаа хүртэл нь түлхэж байх хөшүүрэг тусгагдаагүй.

Засгийн газрууд голчлон өөрсдийгөө идэвхижүүлэх эрхүүдээ сонгодог. Зарим нь хөгжил цэцэглэлд хүрэх зам гэж үзэн ардчилал, өмчлөлийн эрхийг шаардана. Бусад нь «тогтвортой байдал» эдийн засгийн өсөлт, эрүүл мэнд, боловсролын салбар дахь хөрөнгө оруулалт л чухал гэж үзэн эрх чөлөөг хавчихыг оролддог.

Эмнести Интернэшнл бараг 50 жилийн турш хүний эрхийн асуудлыг судалж, кампанит ажил өрнүүлж ирсэн. Тэр хугацааны ихэнх нь хэлмэгдүүлэлт, эрүү шүүлт, аллагын эсрэг иргэний болон улс төрийн эрхүүдэд төвлөрч байлаа. Саяхнаас хүний бүх эрхийн хэрэгжилтийн асуудлаар кампанит ажлаа явуулж эхэлсэн юм. Айдас, аюултай байдлын дунд амьдарч байгаа хүмүүс гачигдалд орох магадлал өндөр. Харин гачигдалд орсон хүмүүсийн эрх зөрчигдөх өндөр магадлал нь эргээд л айдас, аюултай байдлыг бий болгодог. Хүний эрхийн зөрчил нь ядуурлыг бий болгож, даамжруулж байна. Эргээд ядуурал нь хүний эрхийн зөрчлийг бий болгодог.

Хүний эрхийн тухай ойлголтын цөм нь хүн бүр төрөлхийн эрх чөлөөтэй, адилхан нэр төр, тэгш эрхтэйд оршдог. Энэ нь бидний амьдарч буй дэлхийд хүн бүрт адил боломж заяадаг, тиймээс бид амьдралын, аюулгүй байдлын, нөөцийн, оролцооны эрхийн адил үндсэн түвшинтэй гэсэн үг юм.

**Эдгээр эрхээ шаардах цаг болсон.
Нэр төрөө шаард!
Хүнийг хүндэл!**

ЯДУУ АМЬДРАЛТАЙ ХҮМҮҮСИЙН АЖ БАЙДАЛ

Ядуу амьдардаг хүмүүс өөрсдийнхөө тухай ярихдаа гол асуудал нь мөн ч гэсэн зөвхөн эд хөрөнгийн гачигдлын тухай хэлдэггүй. Өөрсдийнхөө амьдралыг өдөрт 1 эсвэл 1.25 доллар зарцуулдаг гэдгээр дүрсэлдэггүй. Харин хүүхдүүдээ сургуульд сургамар байдаг, гэрээс гараад явахдаа айдасгүй амар тайван явмаар байгаагаа ярьдаг. Тэд айдас, дарангуйлал дунд амьдардаг, гэмт хэрэгтэн шиг харагддаг, зөвхөн нийгмийн «зонхилох хандлага»-аас ч биш, өөрсдийнх нь өмнөөс гаргаж байгаа шийдвэрийн гадна орхигддог, үгийг нь хэн ч тоодоггүй тухай ярьдаг. Мөн үндэслэлгүй баривчилгаа, хөл доороос нь ашигт малтмал ухаж авах гэсэн том том компаниудын хүслээс болж амин зуулгаасаа хагацдаг, гадуурхагддаг, шударга ёсыг эдлэх боломжгүй тухай ярьдаг юм.

Ядуурлыг орлого, зарлагын түвшний хүрээнд ойлгох юм бол зүгээр л түүнийг өсгөчихөд асуудлыг «шийднэ». Гэтэл ядуу амьдардаг хүмүүс өөрсдийнх нь өдөр тутмын амьдралд 4 түлхүүр хүчин зүйлийн бүрдэл харилцан үйлчлэж, хүчтэй нөлөөллийг маш тодорхой хэлдэг. Тэдгээр нь хавчигдал, аюул занал, гадуурхагдал болон эрх мэдэлтэнгүүдэд хүрч чаддаггүй буюу үгийг нь үл тоодог байдал юм.

Аюул занал

Хэрэв та ядуу зүдүү амьдралтай аваас өдөр бүр та өөрөө болон гэр бүл тань аюул заналд өртөх эрсдэл дунд амьдрах болно. Таны гэр, эзэмшил, амь зуулга хуулиар хамгаалагдаагүй байх нь элбэг. Мөн өвчлөх, ургац алдах, ажилгүйдэх зэрэг нөхцөл үүссэн үед бага ч гэсэн нэмэр үзүүлдэг нийгмийн халамжийн ямар ч төрөлд хамрагдах бараг боломжгүй. Ядуу хүмүүс аюулгүй тогтмол ажлын байртай, эсвэл ажил олгогчтой харьцахдаа эрх мэдэлтэй байна гэж бараг үгүй.


Гэмт бүлгүүдийн дарамтанд ядуучууд харьцангуй ихээр өртдөг бөгөөд ядуу эмэгтэйчүүд хууль, цагдаагийн хамгаалалтаас гадуур, ямар нэгэн дарамтанд байх нь олонтаа. Харин дээгүүр албан тушаалтай, нөлөө бүхий хүнд хууль ёс маш сайн үйлчилнэ. Өөрсдөө ажиллаж, боловсрон, эвлэлдэн



2007- 2008 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээс харахад Монгол улсад ядуурлын түвшин 35,2 хувь болсон бөгөөд 930,0 мянга орчим хүн ядууралд өртсөн байна гэсэн дүн гарчээ. Энэ нь 100 хүн тутмын 35 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна гэсэн үг юм.

Ядуурлын дүр төрхийг бүс нутгаар авч үзвэл нийслэл хотод хамгийн бага буюу хүн амын тавны нэг хувь нь ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай байна. Үүний дараа Төвийн бүс орж байгаа бөгөөд арван хүний гурав нь ядуу байна. Баруун, Хангай, Зүүн бүс нутгуудад ядуурлын хамралтын хүрээ ойролцоо буюу хүн амынх нь бараг тал хувь нь ядууралд өртөөд байна.

Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг хот, хөдөөгөөр, суурьшлаар авч үзвэл хотод ядуурал хөдөөгөөс нэлээн бага буюу хамралтын хүрээ нь 27 хувь, хөдөөд 47 хувь байна.



нэгдэж амьдралаа дээшлүүлэхээр оролдож байгаа хүмүүст эрх зүйн туслалцааны хүртээмж хомс.

Гадуурхагдал

Ядуу амьдралтай хүмүүс өөрсдөд нь маш их хэрэгцээтэй төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад орох эрхгүй юм шиг санагддаг тухайгаа ярьдаг. Шүүх, цагдаа, халамжийн газрууд, хотын захиргаа, сургууль гээд уг нь бүх иргэдэд тэгш үйлчлэх ёстой байгууллагууд ядуу хүмүүсийг ялгаварлаж, дургүйцэж ханддаг байна. Хэрэв та ядуу, эмэгтэй хүн бол гэр бүл, хүрээлэл дотроо шийдвэр гаргалт, эрх мэдлийн хүрээнээс давхар давхар гадуурхагдана гэсэн үг. Баян, ядуу бүлгүүдийн жирэмсэн эхийн эндэгдлийн харьцаа нь энэхүү алагчлал, гадуурхалыг хамгийн тодорхой харуулж чадах юм. 2008 онд Ядуусын эрх зүйн

хүртээмжийг сайжруулах Комиссын гаргасан мэдээгээр 4 тэрбум хүн буюу дэлхийн хүн амын дийлэнх нь хуулиас гадуурхагдсан, буурай хөгжилтэй орнууд дахь хүүхдүүдийн 70% нь төрсний ямар нэг гэрчилгээгүйгээр зүгээр л явж байна гэжээ. Энэ нь эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ авах, нийгэм, улс төрийн, эдийн засгийн амьдралд оролцоход нь саад болж байна.

Үгийг нь тоож сонсдоггүй байдал

Гадуурхагдал нь ядуу амьдралын бас нэг үр дагавар болох эрх мэдэлтэнд үл тоомсорлогддогтой нягт холбоотой. Ядуу амьдралтай хүмүүс үзэл бодлыг нь хэн ч тоодоггүй гэж боддог. Эвлэлдэн нэгдэх гэж оролдвол нухчин дардаг, тэдэнтэй холбоотой мэдээллийг нуун дарагдуулж, зөвлөлгөөн, хэлэлцүүлэг нь үр дүнгүйдэн, эсвэл тэдний талд муугаар эргэдэг.

2008 онд, Тунисийн зүүн өмнөх Гафса бүсийн томоохон ажил олгогч Гафса Фосфат компани ажилтан шалгаруулалтынхаа дүнг танилцуулсан нь нийтийн хөдөлгөөн өрнөх нөхцөл болжээ. Шалгаруулалтын үр дүн маргаантай, луйвартай байгаа тухай гомдол гаргасан нь амжилтад хүрээгүй ажилчид Тунисийн ҮЗ-ийн Нэгдсэн Холбоотой хамтран жагсчээ. Хөдөлгөөн бусад хотуудад өргөжин тэлж, эрх баригчид цагдаа, хамгаалалтын асар их хүчээр даржээ.

Хүмүүс зуу зуугаараа баривчлагдаж, бослогыг удирдсан гэдгээр 38 хүнийг «нийтийн болон хувийн өмчид халдах зорилгоор гэмт бүлэглэл байгуулсан», «үүргээ гүйцэтгэж буй албан тушаалтанд зэвсэглэн халдсан» зэрэг үндэслэлээр хэрэгт татжээ.

Тэдний ихэнх нь шударга бус шүүхийн шийдвэрээр хорих ялаар шийтгүүлсэн байна. Эмнести Интернэшнл нь дээрх хүмүүсийг үзэл санааны хоригдол гэж үзэж байна.

Үзэл бодлоосоо үүдэн хавчигдах эсвэл ялгаварлагдан үл тоомсорлогдох нь үр нөлөөний хувьд ямар ч ялгаагүй. Тэдний үг бусдад хүрэхгүй. Дэлхийн хамгийн ядуу гэгдэх орнууд хамгийн их дарангуйлалтай орнууд байдаг нь зүгээр ч нэг тохиолдлын хэрэг биш. Ардчилсан зарчмуудыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн орнуудад ч гэсэн ядуу амьдардаг хүмүүс өөрсдийнхөө үзэл бодлыг бусдад хүргэхдээ тодорхой хүндрэлүүдтэй үргэлж тулгарч байдаг.

Хавчигдал, аюултай байдал дунд, наад захын үйлчилгээ авах боломжгүй, засгийн газартаа хаягдсан байдлаар амьдарч, сэргийлж болохуйц нөхцөлд амиа алдаж, бодлого тодорхойлохын гадна орхигдож, үзэл бодлоо илэрхийлсэн ч үл тоомсорлогдож, бүр дарамтлуулдаг бол ядуу зүдүү байдал мөн.

ХААНААС ЭХЛЭХ ВЭ?

Дараагийн 6 жилд ЭИ түүхэндээ хамгийн том судалгаа, кампанит ба идэвхижүүлэлтийн ажлыг эхлүүлэх болно. 50 жилийн турш хүний эрхийн зөрчлийг судалж ирсэн оновчтой, шударга арга барил, Засгийн газрууд болон НҮБ-ыг улс орнуудын үндэсний хууль тогтоомжийг сайжруулах, зөрчигдсөн газар хариуцлага тооцох талд итгүүлж чадаж байсан амжилт зэрэг дээрээ тулгуурлан бид ядуу хүмүүст өөрсдөд нь эрх мэдэл олгох, ирээдүйгээ тодорхойлох үйл явцад оролцож, үзэл бодлоо илэрхийлэх орон зай гаргаж өгөхөөр ажиллана. Бидний ядуурал бол дэлхий дээрх хамгийн аймшигтай хүний эрхийн зөрчил мөн гэдгийг ойлгуулах



2008 оны сүүлээр ундны цэвэр усаар хангагдаагүй, бохирын систем хуучирсан зэрэг асуудлыг Засгийн газар нь шийдвэрлээгүйгээс үүдэлтэй булчин задрах тахал Зимбабве даяар тархчээ. Энэ явдал тус улсын зохион байгуулалт муутай эрүүл мэндийн салбарыг хүнд байдалд оруулав.

Эрүүл мэндийн салбар нь хангамжийн материалаар хомсдож, дэд бүтэц, тоног төхөөрөмж, эмч нарын мэдлэгийн түвшин гээд бүх юм амжилттай болсонгүй. Хараре дахь нийтийн эмнэлэгт сард ойролцоогоор 3000 эмэгтэй амарждаг байсан бөгөөд тэдний 10 хүртэлх хувь нь мэс заслын аргаар төрөх шаардлагатай болдог байв. Гэтэл эмнэлэг нь хаагдсан учир жирэмсэн эхчүүдэд үзүүлэх үйлчилгээ зогссон байжээ.

Эмнэлгийн ажилтнуудыг Эрүүл мэндийн сайдад өргөдөл өгөх гэж байхад нь хүнд зэвсэглэсэн цагдаа нар дайран орж, хүчээр тараахдаа эмнэлгийн хэд хэдэн ажилтанд халджээ. Тэд засгийн газраас эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, хүрэлцээтэй болгон сэргээхийг шаардаж байжээ. Халдлагаас цөөхөн сарын дараа буюу 2009 оны 2 дугаар сард Зимбабегийн ерөнхийлөгч 85 кг жинтэй бялуугаар төрсөн өдрөө тэмдэглэсэн. Түүний дэмжигчид төрсөн өдөрт нь зориулж 250,000 доллар босгосон ч, өрдөө хэд хоногийн дараа тэд хөршүүдээсээ 2 тэрбум долларын тусламж гуйж байв.

болно.

Бид ЭИ туршлага хуримтлуулж чадсан, үйл ажиллагаа үр дүнгээ өгнө гэж үзэж, хавчигдал, аюултай байдал, гадуурхагдал, үл тоомсорлогдох байдал зэргийн харилцан хамаарлыг хүчтэй харуулж байдаг хүний эрхийн зөрчлийн гол гэсэн цөөхөн хэдэн талбар, хэлбэрүүдээс ажлаа эхлэхээр төлөвлөв. Бидний хамгийн гол зорилго хүмүүсийг ядуу байлгадаг хүний эрхийн зөрчлийг зогсооход оршино.

Эхийн эндэглэл

Жил бүр жирэмслэлтэй холбоотойгоор нас бардаг хагас сая гаруй эмэгтэйчүүдийн бараг бүгдэд нь

зохистой цагт нь хэрэгцээтэй эмнэлгийн үйлчилгээ үзүүлж чадсан бол аварч болохоор байдаг ажээ. Жирэмсний үеийн үйлчилгээ, хяналт зэрэг шаардлагатай эмнэлгийн үйлчилгээний үнэ нь ядуу эмэгтэйчүүдэд хэрэгтэй үйлчилгээгээ авах боломжийг нь хязгаарладаг. Ядуу амьдралтай, эсвэл алслагдсан хүмүүст эмнэлгийн байгууллагад очих нь хүртэл хүндрэлтэй. Тээврийн зардал өндөр, эсвэл очих зам нь хэцүү байдаг. Ядуу амьдралтай эмэгтэйчүүд, охид ялангуяа хэрэв бичиг үсэг, боловсролгүй бол жирэмсний хүндрэлийн талаар мэдээлэл авч чадахгүй байх нь ч бий.

Төрөхийн хүндрэлээр нас барсан эмэгтэйчүүдийн дийлэнх нь буюу 95 гаруй хувь нь ядуу, буурай хөгжилтэй



© Б. Чингүүн

Өмнөговь аймаг хүүхдийн эндэгдэл хамгийн ихтэй байгаа дөрвөн аймгийн нэгэнд ороод байна. Аймгийн хэмжээнд 2005-2009 оны хоёрдугаар сарын байдлаар зургаан эх эндсэн харамсалтай явдал гарчээ. Судалгаанаас үзэхэд, эндсэн эхийн 33.4 хувь нь гэрийн ажилтай, 50 хувь нь малчин бөгөөд 17 хувь нь жирэмсний хяналтанд хамрагдаагүй байжээ.

Жирэмсний аюултай шинжийн талаар хувь хүн гэр бүл, хамт олны мэдлэг хомс, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар, хариуцлага харилцан адилгүй, анхан шатны эмнэлгүүдэд төрөлттэй холбоотой эмгэг хүндрэлийн оношлогоо жигд биш, эрхтэн тогтолцооны эмгэгтэй эмзэг бүлгийн эмэгтэйчүүд жирэмслэх нь ихсэж байгаа, эхчүүд хэт хүндэрсэн хойноо эмнэлэгт ханддаг, халамжийн тэтгэлийн хамрах хүрээ ихэссэнээс эрсдэлт бүлгийн эхчүүдийн төрөлт нэмэгдсэн гэх мэт хүчин зүйлүүд эндэгдэлд нөлөөлж байгаа ажээ.

Сүүлийн 10 жилд хөдөөнөөс хот руу шилжих шилжилт ид явагдаж байгаа бөгөөд гэр бүлийн шилжилт зонхилж байна. Шилжин суурьшигчдын зонхилон амьдарч буй гэр хорооллын хөгжлийн дүр төрх, өрхүүдийн ахуйн нөхцөл муу хэвээр байна.

Улаанбаатарт шилжин суурьшсан өрхүүдийн 35,6% стандартын бүс нүхэн жорлон 12,1% огт жорлонгүй 30 орчим хувь нь хог хаягдалаа ил задгай нүх, суваг, шуудуунд хаядаг. Улаанбаатарт суурьшсан өрхүүдийн 60 хувь хүрэхгүй нь өөрийн эзэмшлийн газартай байгаа хэдий ч тэдгээрийн ердөө л 39-56 хувь нь л газраа өмчилж авчээ. Үүний шалтгаан нь бичиг баримтын зөрчилтэй, асуудлыг хэрхэн хөөцөлдөхөө мэдэхгүй, шат дамжлага их, зардал өндөр гэсэн шалтгаан харьцангуй өндөр хувьтай байна.

Шилжин суурьшигчдын олонх нь эрүүл мэндийн үйлчилгээнд сэтгэл хангалуун бус байгаа төдийгүй өрхийн байршил буюу зайнаас хамааран эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж мөн хязгаарлагдаж байна. Шилжин суурьшигчдын дунд бүртгэлгүйн улмаас хүүхдээ сургуулиас завсардуулсан, сургуульд суралцалж чадахгүй байгаа шилжигчид цөөнгүй байна.

/НҮБ-ын хүн амын сангийн хийсэн Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагавар судалгааны тайлангаас/

орнуудад хамаардаг. Гэхдээ баян улсуудад ч гэсэн төрөхийн хүндрэлээр мянга мянган эмэгтэйчүүд нас бардаг ажээ. Тэдний ихэнх нь нийгмээс гадуурхагдсан, эсвэл ядуу бүлгийнх байдаг. АНУ-д африк гаралтай америкчуудын жирэмсний нас баралт нь цагаан арьст эмэгтэйчүүдийнхээс 3 дахин их ажээ. АНУ-ын 46 гаруй сая хүн эрүүл мэндийн даатгалгүй бөгөөд өртгөөс нь үүдэн эрүүл мэндийн үйлчилгээ авахаа хойшлуулах, эсвэл татгалзах үзэгдэл нийтлэг байдаг.

Эмэгтэйчүүд хэзээ жирэмслэхээ шийдэх эрхтэй ч ихэнхдээ хамгаалалт эсвэл жирэмслэлтээ хянах мэдээллээс хочорсон байдаг ажээ. Цаашилбал

эмэгтэйчүүд охидууд өөрийнхөө биеийг мэдэх эрхгүй болдог тохиолдол ч бий.

Ээж нь төрөхийн хүндрэлээр нас барсан гэр бүлийн амьжиргаа улам дорддог. Тэд амь зуулгаа алдана. Учир нь гэрийн ажил хийдэг, хүүхдээ асардаг хүнгүй болно шүү дээ.

— Ядуусын хороолол —

Дэлхийд ядуусын хороолол гэгддэг 200,000 гаруй газар байдаг. Гэр хороолол, G – хороолол гэх мэт янз янзаар хэлэгддэг энэ газар тив тивд оршиж, 1 тэрбум хүн амьдардаг. Тэд бүгд зохих орон байргүй, ариун цэвэр муу, цэвэр ус, тог цахилгаангүй, олноор бөөгнөрсөн хүнд дарамтанд

амьдардаг. Олонхийнх нь амьдралын хэлбэрийг «хууль бус», «дэг журамгүй» гэж тодорхойлдог. Тэнд амьдардаг хүмүүс бараг бүгд оршин суух эрх нь баталгаагүй, түүнийхээ төлөө тэмцэх эрх мэдэлгүй учраас байнга албадан нүүлгэгдэж мэдэх эрсдэлээс салддаггүй.

Худалдаж авах боломжтой байр, орон сууц байхгүй учир хөгжлийн түвшин доогуур хөдөөнөөс хот руу орж ирэхээс өөр сонголт хүмүүст үлддэггүй.

Ядуусын хороололд амьдарч байгаа хүмүүс эд хөрөнгийн гачигдалд ордог нь ойлгомжтой. Түүнчилэн нь цагдаа нар болон гэмт бүлэглэлүүдийн зүгээс ирэх байнгын заналхийлэл, ямар ч сануулгагүйгээр албадан нүүлгэх эрсдэл доор ихээхэн аюултай байдалд амьдардаг. Тэд цэвэр ус, ариун цэвэр, эрүүл мэнд, боловсролын наад захын үйлчилгээнүүдээс тасардаг. Ядуу хүмүүсийг алагчладагаас үүдэн шударга ёсыг эдлэх боломжгүй. Амьдралд нь нөлөө бүхий үйл ажиллагаа, шийдвэрт ядуусын хорооллын хүмүүсийн дуу хоолойг үл хайхардаг. Амьдрах орчноо сайжруулах, эсвэл нүүлгэлтийн дараа өөр байранд орох тухай шийдвэр гаргахад оролцохыг ядуусын хорооллынхонд санал болгодоггүй, зөвшөөрдөг ч үгүй.

Дэлхий даяар ядуусын хороололд амьдардаг хүмүүсийн тоо маш ихээр өсч байна. 2030 он гэхэд 2 тэрбум хүн ядуусын хороололд амьдарна гэсэн зарим тооцоо ч бий.

== Пүүс компаниудын хариуцлага ==

Пүүс компаниуд нь хувь хүн, нийгмийн бүлгүүдийн эрхэнд их нөлөөтэй.

Тухайлбал: шинэ ажлын байр бий болгох, төрийн үйлчилгээг санхүүжүүлэх татварын орлогыг нэмэгдүүлэх зэрэг зэрэг үр дагавартай байж болно. Гэвч компаниуд хээл хахууль, улс орнууд дахь хуулийн сул тогтолцоо, хариуцлага тооцох боломжгүй байдлыг дэвэргэснээр хүний эрхийг зөрчих нь нийтлэг.

Ялангуяа ашигт малтмалын салбар дахь төслүүд нь хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл зэрэг хүний эрхийг хөндөж болзошгүй нөлөөллийг тооцолгүйгээр хэрэгждэг.

Тэд хүмүүсийг албадан нүүлгэдэг. Хүмүүс нүүхгүйгээр шийдсэн ч гэсэн газрыг нь ухааж, усыг нь бохирдуулснаар тэдний уламжлалт амь зуулга, цаашлаад бүр аминд нь аюул учирч мэднэ. Мөн компаниуд өмчөө хамгаалахын тулд бүр сөргөлдөөн ч үүсгэх боломжтой. Хамгийн муугаар тооцоход пүүс компаниуд

Засгийн газартай нь хамтран шударга ёсыг эрэлхийлэгсдийг хүчирхийлэл, айлган сүрдүүлэлтээр нухчин дарж байна.

Нийгмийн холбогдох бүлгүүд нь пүүс компаниудын үйл ажиллагааны нөлөөний тухай мэдээлэл авах боломжгүй, өөрсдөд нь нөлөөлөхүйц шийдвэрүүдэд оролцох эрхгүй тохиолдолд эрх нь зөрчигдөх явдал улам даамжирдаг. Дээрээс нь шударга ёсыг эдлэх боломжгүй байх, засгийн газар нь анхны гэрээндээ хүний эрхийг тусгаж өгөөгүй, эсвэл олон талт хэлэлцээрийн хүрээнд тус компанийг хариуцлагад татахаас татгалзах зэрэг нь зөрчлийг гааруулах нь ойлгомжтой.

Хүний эрхийн зөрчлүүд хувьцаа эзэмшигчдийг баяжуулж байхад, хөгжиж буй орнууд дахь ядуу амьдралтай хүмүүс пүүс компаниудын болчимгүй үйлдлийн уршигийг үүрч байна. Дотоодын хуулийн цоорхой, хууль хэрэгжихгүй байх болон олон улсын хэмжээнд хариуцлагын тогтолцоогүй зэрэг нь хөгжиж буй

орнуудад асар муу үр дагавар авчирдаг. Ялангуяа нутгийн уугуул хүмүүсийн эрх хамгийн их зөрчигддөг бөгөөд бараг хамгаалагдаагүй, нөхөн төлбөр авах боломжгүй байдаг.

Байгалийн нөөц баялаг хамгийн ихтэй, ялангуяа үндэсний орлого нь нөөцөөсөө хамаардаг орнууд дэлхийн хамгийн ядуу улсууд байдаг. Ашигт малтмалаар хамгийн баян 25 орны 12 нь, газрын тос хамгийн элбэгтэй орнуудын 6 нь Дэлхийн Банкны ангилснаар «их өртэй, маш ядуу орон», хүний хөгжлөөр хамгийн доод түвшинтэй оронд тооцогддог.

Их нөөц баялагтай хирнээ ядуурлын өндөр түвшинд байх нь нийцгүй зүйл. Уг нь ашигт малтмалын салбарт асар олон компани өрсөлдөж байдгаас хамааран хөрөнгө оруулалт нь ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжихөд их хувь нэмэр оруулах ёстой. Хэрэв компаниуд үйл ажиллагааныхаа хүрээнд хүний эрхийг хүндэлдэг бол энэ нь боломжтой зүйл.



© Б. Чингүүн



ГИНЖИЙГ ЯАЖ ТАСЛАХ ВЭ

2008 оны санхүүгийн цочролоос үүдэн шатахуун, хоолны хомсдолоос болоод доод тал нь 100 сая хүн ядуурав. Зөвхөн эдийн засгийн өсөлтөнд тулгуурласан ядуурлыг бууруулах арга нь оновчтой бус, найдваргүй юм. Одоогийн санхүүгийн хямрал нь ганцхан эдийн засгийн өсөлтөнд суурилах нь ямар хэврэг болохыг тод томруун харуулж байна.

Дэлхий даяар эдийн засаг уналтанд орж Хятад, Энэтхэг, Бразилийн эдийн засгийн өсөлт удааширч байна. Ядуу орнууд, ялангуяа Африкийн улсууд дахь хөрөнгө оруулалт, худалдаа, тусламж зэрэг багасч байгаа нь тухайн орны хүн амд сөргөөр хүчтэй нөлөөлж байгаа юм. Экспортын эрэлт багасах, гадаадын хөрөнгө оруулалт буурах зэрэг нь экспортоос хамааралтай орнуудын эдийн засгийн өсөлтийг удаашруулж байна. Цагааа ажилчдын орлого нь чухал ач холбогдолтой орнууд ч гэсэн маш хүнд байдалд орлоо.

Дэлхийн эдийн засгийн уналтаар ядуусын амьдралыг золиослох нь ямар

ч утгагүй билээ. Эдийн засгийн өсөлт ядуурлыг бууруулах аргын нэг чухал хэсэг нь мөн ч дангаараа хариулт өгч чадахгүй. Бид ядуу хүмүүсийг өөрсдийнхөө эрхээ эдлэхийг шаардахад нь туслах ёстой. Тэгснээр тэд өөрсдийнхөө хувь заяаны золиос биш эзэн нь байж чадна.

Эмнести Интернэшнл ямагт хувь хүмүүсийн орон зайг хамгаалж ирсэн. Бид үзэл санааны хоригдлуудыг суллахын төлөө тэмцэхдээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, орон зайд төвлөрч ажилладаг байлаа. Харин одоо бид тэрхүү орой зай нь ядуу хүмүүс өөрсдийнхөө эрхийг эдлэхийг шаарддаг

болохын угтвар нөхцөл мөн гэдгийг ойлгох хэрэгтэй.

Хэрэв Засгийн газрууд ядуучуудыг ядуусын хороололд нь хашиж, үхлийн сандал, эрүү шүүлтээр тэрхүү «хорих лагерьт» байлгасаар байх аваас бид тэдний эдийн засаг өсч байгаа гэсэн үгийг нь огт тоохгүй. Ядууст өөрсдийг нь ядуу хэвээр байлгадаг үл үзэгдэх «гинж»-нээс мултрахад нь туслах боломжтой бөгөөд тэгэх ч «шаардлагатай».

Хүний эрхийн зөрчил ядуурлыг бий болгож, даамжруулж, харин ядуурал нь эргээд хүний эрхийн зөрчлийг бий болгодог.

ХҮНИЙГ ХҮНДЭЛ

Яаралтай арга хэмжээ авцгаая

Ядуусын хороололд амьдарч буй иргэдийг хамгаалж, жирэмслэлтийн улмаас амь насаа алдах эхийн эндэгдлийг зогсоож, бизнесийн байгууллага, пүүс компаниудыг хариуцлагатай болгохын тулд үг ярианаас илүү үйл ажиллагаа чухал байна. Хэрвээ доорхи 3 чиглэлээр бид амжилтанд хүрч чадвал ядуурал багасах болно.

Хариуцлага тооцох

- Төр засаг, үндэстэн дамнасан пүүс компани, хувь хүмүүс зэрэг үндэсний болон олон улсын оролцогчид ядуурлыг гүнзгийрүүлж буй хүний эрхийн зөрчилтэй тэмцэх
- Аливаа засгийн газар хүчирхийлэл, ялгаварлал, авилгалыг хянахаар тэмцэж буй хүмүүсийн үйл ажиллагаанд саад хийхгүй байх
- Эдийн засаг нийгэм соёлын эрхийг олон улс, бүс нутаг болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах
- Үндэсний хилээр хязгаарлагдахгүй хүний эрхийг хамгаалах үүрэг хүлээх.

Эрхээ эдлэх

- Эрхээ сэргээлгэх, тэгш хүртээмжтэй үйлчилгээ авахад саад болж буй алагчилсан хууль, бодлого, практикийг өөрчлөх, халах
- Шударга ёсыг шаардах, үйлчилгээ авах, нөөцөөс хүртэх үед ядууст тулгарах бэрхшээлийг арилгах тодорхой алхам авч хэрэгжүүлэх,
- Мянганы Хөгжлийн Зорилт гэх мэт үндэсний болон олон улсын түвшинд ядуурлыг бууруулах талаар авч буй арга хэмжээг хүний эрхийн үүднээс шинжлэн тогтоох.

Идэвхитэй оролцоо

- Олон улсын хэмжээнд ядуурлыг бууруулах хөгжлийн хөтөлбөр, хэрэгжүүлэх ажиллагаанд ядуусыг оролцуулах тогтолцоотой байх
- Үндэсний хэмжээнд хүний эрхийн хамгаалагч, иргэний нийгмийн идэвхитнүүдийг төрөөс хамгаалдаг, хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, хуран чуулах боломжтой байх
- Ядуу хүмүүсийг оролцох боломжоор хангагдах

demanddignity.amnesty.org
www.amnesty.mn

Нобелийн шагналт хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллага нь олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт эдлүүлэх зорилгоор кампанит үйл ажиллагаа явуулдаг хамгийн ардчилсан дэлхий нийтийн хүний эрхийг хамгаалагчдын хөдөлгөөн юм. Дэлхийн 150 гаруй орны 2,2 сая гишүүд дэмжигчидтэй.

Хүний эрх = Бага ядуурал

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Бид хэвлэл тутаасаа 1 төгрөгийг Монголын Эмнести Интернэшнл-д хандивладаг бөгөөд бидний энэ хандив ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ үйлсэд зориулагддаг.

Хаяг: Сүхбаатар дүүрэг,
6-р хороо,
Бага тойруу - 44, 10 тоот
Утас/факс: 976-11-324705
И-мэйл: aimncc@magicnet.mn
www.amnesty.mn

